



**Харилцаа холбооны зохицуулах хорооны
2022 оны ээлжит 12 дугаар хуралдааны
мэдээлэл**

Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хорооны 2022 оны ээлжит 12 дугаар хуралдааныг 2022 оны 12 дугаар сарын 22-ны өдөр холимог оролцоотой (биеэр болон цахим) хэлбэрээр зохион байгуулав.

Зохицуулах хорооны 2022 оны ээлжит 12 дүгээр хуралдаанаар “Телевизийн хөтөлбөрт тавигдах шаардлага”-д нэмэлт оруулах тухай (Хорооны 2021 оны 01 тоот тогтоол); Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг нээлттэй сонгон шалгаруулалтаар 2023 онд олгох тухай (Тэмдэглэлийн төсөл); Телевизийн хөтөлбөрт мониторинг хийсэн тайлан (KPI)-танилцуулга (2022 оны 01-10 сар); “Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ”-г шинэчлэн батлах тухай; Давамгайл байдалтай үйлчилгээ эрхлэгч Юнивишн ХХК-ийн үндсэн үйлчилгээний үнэ тарифыг хянан батлах тухай; Харилцаа холбооны зохицуулах хорооны 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, орлог зардлын төлөвлөгөө, байгууллагын 2024-2025 оны төсвийн төсөөлөл”-ийг батлах тухай; Зөвшөөрлийн тухай хуулийг хэрэгжүүлж эхлэхтэй холбогдуулан боловсруулсан багц арга хэмжээний тухай: “ХХЗХ-ны хуралдааны дэг”-д өөрчлөлт оруулах тухай (2019 оны 28 тоот тогтоол); Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай (2021 оны 34 тоот тогтоол); Дотоодын хэрэглээний холбооны сүлжээнд зохицуулалт хийх журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2020 оны 65 тоот тогтоол); “Харилцаа холбооны зах зээлд шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх журам”-д өөрчлөлт оруулах тухай (2021 оны 57 тоот тогтоол); “Мэдээллийн сүлжээ ашиглах, үйлчилгээ эрхлэх зохицуулалтын журам” батлах тухай; Тусгай зөвшөөрлийн тухай (ТЗ олгох, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох тухай); “Улаанбаатар хотын арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтын дүнгээр түдгэлзүүлэх тухай) зэрэг асуудлыг хэлэлцэн нийт хорооны 12 тогтоолыг баталж, хорооны хуралдааны 2 тэмдэглэлээр хугацаатай удирдамж, чиглэлийн холбогдох бүтцийн нэгжид үүрэг болгохоор тогтов.

Монгол Улсын Их Хурлын 2019 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн хуралдаанаар Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийг баталж, 2020 оны 07 дугаар сарын 01-ний өдөр хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлсэн. Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 23 дугаар зүйлд заасан хөтөлбөрт тавигдах шаардлагыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн мөн хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.6-д заасны дагуу Зохицуулах хорооны 2021 оны 01 дүгээр сарын 29-ны өдрийн хуралдааны 01 тоот тогтоолоор “Телевизийн хөтөлбөрт тавигдах шаардлага”-ыг батлан ХЗДХЯ-ны Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд хянуулан 5059 дугаар бүртгүүлэн мөрдөж байгаа билээ. Тус хорооны ӨНЗГ-аас эрх бүхий байгууллагуудаас удаа дараа ирүүлсэн санал хүсэлт болон нөхцөл, шаардлагын хэрэгжилтэд үнэлгээ, мониторинг хийсэн дүгнэлтийг үндэслэн дараах 3 заалтыг 2021 оны 01 тоот тогтоолын хавсралтаар баталсан “Телевизийн хөтөлбөрт тавигдах шаардлага”-д нэмэлт оруулахаар Захиргааны ерөнхий хуулийн дагуу холбогдох танилцуулга, тогтоолын төсөл, саналын товчоо, нөлөөллийн шинжилгээг

боловсруулсан байна. Тус хуралдаанаар энэхүү тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай асуудлыг авч хэлэлцээд, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.6 дах заалтыг үндэслэн 2022 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 60 тоот “Телевизийн хөтөлбөрт тавигдах шаардлагад нэмэлт оруулах тухай” тогтоолыг батлав. Тогтоолыг баталснаар хорооны 2021 оны 01 тоот тогтоолын хавсралтад “3.10.5 Энэхүү шаардлагын 3.10.2-т заасан хүүхдийн нэвтрүүлгийн нийт цагийн 20 хувиас доошгүй нь дохионы хэлний хэлмэрчтэй эсхүл бичгэн тайлбартай байна.” гэсэн агуулгатай заалтыг нэмсэн болно. Уг тогтоолыг ХЗДХЯ-нд хянуулан нэмэлтээр бүртгүүлэхээр албан тоотор хүргүүлж, ХЗДХЯ-ны Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 5059 бүртгэлтэй 2021 оны 01 тоот тогтоолд оруулсан 2022 оны 60 тоот тогтоолыг хянаж үзээд, тогтоолоор оруулсан нэмэлтийг 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр ХЗДХЯ бүртгэсэн болно.

Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 6 дугаар зүйлд Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний төрлийг тодорхойлж, эдгээр төрлүүдээр тусгай зөвшөөрөл олгох ангиллыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.16.5; 15.16.6; 15.16.7 дахь заалтаар тогтоосон. Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д “Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээг Зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн дагуу эрхэлнэ.” гэж; мөн хуулийн 7.4.5-д “энэ хуулийн 6.1.6-д зааснаас бусад төрлийн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний тусгай зөвшөөрлийг нээлттэйгээр сонгон шалгаруулах;” гэж; Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2-т “хуульд заасан тусгай зөвшөөрөл олгох, хугацааг сунгах, тусгай зөвшөөрөлд нэмэлт, өөрчлөлт оруулах, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага болон холбогдох журмыг батлах, гэрээ байгуулах, биелэлтэд хяналт тавих;” гэж тус тус заасны дагуу Харилцаа холбооны зохицуулах хорооноос өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг олгохтой холбоотой харилцааг хуульчилсан.

Тус хорооноос өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг нээлттэй сонгон шалгаруулалтаар олгох процессыг Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.7.(б)-д заасан “Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийн журам”-ын хүрээнд зохион байгуулж, тус Хорооны хуралдааны 2020 оны 91 тоот тогтоолоор 2021 онд, 2021 оны 71 тоот тогтоолоор 2022 онд нээлттэй сонгон шалгаруулалтаар олгох өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн төрөл, тоо (квот)-г тус тус баталж, тогтоолын биелэлтийг хангуулан ажилласан юм. Монгол Улсын Их Хурлын 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн чуулганы хуралдаанаар Зөвшөөрлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдаж, 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэхээр тогтоосон бөгөөд Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг баталсантай холбогдуулан Улсын Их Хурлын 2022 оны 35 тоот тогтоолоор зөвшөөрлийн харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актыг Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-тай нийцүүлэх, Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-иар зөвшөөрлийг нэгтгэсэн, хассан, шилжүүлсэн, зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдийн харьяалал өөрчлөгдсөнтэй холбогдуулан зөвшөөрлийн харилцааг зохицуулж байгаа холбогдох шийдвэрийг мөн хуульд нийцүүлэх, холбогдох арга хэмжээ авах, зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж Монгол Улсын Их Хуралд 2023 оны 01 дүгээр сарын дотор танилцуулах, холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг өргөн мэдүүлэх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгасан. Зөвшөөрлийн тухай хуулийн 5.6 дугаар зүйлээр уг хуулийн 8.1 дүгээр зүйлд заасан тодорхой төрлийн

тусгай зөвшөөрлийг дуудлага худалдаа зохион байгуулах, сонгон шалгаруулалтын журмаар олгох харилцааг зохицуулж, өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн төрлөөс зөвхөн өргөн нэвтрүүлгийн радио, телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг буюу уг хуулийн 8.1 дүгээр зүйлийн 9 дэх хэсгийн 9.7 дахь заалтад заасан тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтын журмаар олгоно гэж тодорхойлсон байгаа нь Өргөн нэвтрүүлгийн тухай хуулиар тодорхойлсон өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх эрх зүйн үндэс, баримтлах зарчимд харшилсан, мөн хуулийн 7 дугаар зүйлийн 7.4.5 дахь заалттай зөрчилдөж, хуулийн хийдэл, зөрчлийг үүсгэх нөхцөл үүсээд байна. Тодруулбал, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулиар энэ хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.6-д заасан төлбөртэй радио, телевизийн тусгай зөвшөөрлөөс бусад төрлийн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг нээлттэйгээр сонгон шалгаруулах хуулийн зохицуулалт хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа билээ. Түүнчлэн хууль тогтоогч Зөвшөөрлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 17-д “Зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбогдсон захиргааны хэм хэмжээ тогтоосон акт гаргахыг хориглоно.” гэж тодорхойлсон нь Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсгийн 30.1.7.(б)-д заасан өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийн журмын зохицуулах харилцаа, агуулгыг эргэж харах, эрх зүйн үндсийг тодруулах хэрэгцээ шаардлагыг бий болгосон.

Зөвшөөрлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад нийцүүлэн холбогдох хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн тогтоомжийн төслийг Улсын Их Хурлын 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэхийг дэмжиж, төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн болно. Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээр 2023 онд нээлттэй сонгон шалгаруулалтаар олгох өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн тоо тогтоох харилцааг тус хорооны 2020 оны 64 тоот тогтоолын хавсралтаар батлагдсан “Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийн журам”-ыг үндэслэн тогтоож, батлах нь Захиргааны ерөнхий хуульд заасан захиргааны акт, түүнийг батлахад тавигдах шаардлагад нийцэхгүй буюу захиргааны актын хууль зүйн үндэслэл, захиргааны акт гаргах хуулиар тодорхойлсон эрхийг тодорхой заах нөхцөл хангагдахгүй, эрх зүйн маргаан дагуулах эрсдэлтэй гэж үзэж байна.

Иймд дээрх зөвшөөрлийн тухай холбогдох хууль тогтоомж, эрх зүйн нийцлийн үүссэн түр эрсдэл, зөрчилтэй нөхцөл байдлыг харгалзан үзээд, хорооны ӨНЗГ-аас 2023 онд нээлттэй сонгон шалгаруулалт явуулах шаардлагатай өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн төрөл, тоо (квот)-г тогтоох шийдвэр гаргах хугацааг түр хойшлуулах, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.3-т заасан дүгнэлт, судалгааны хамт “Нээлттэй сонгон шалгаруулалт, өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн тухай” тухай үндэслэл, танилцуулга, 2023 оны эхний хагас жилд багтаан шийдвэрлүүлэх тухай хорооны хуралдааны тэмдэглэлийн төслийн хамт боловсруулан хэлэлцүүлэв. Уг асуудлаар, Зохицуулах хорооны 2022 оны ээлжит 12 дугаар хуралдааны “Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн тоо тогтоох тухай” 12 дугаар тэмдэглэлээр хугацаа заасан холбогдох удирдамж, чиглэлийг бүтцийн нэгжийн удирдлагад үүрэг болгож, хорооны 2020 оны 64 тоот тогтоолын хавсралтаар батлагдсан “Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийн журам”-ын 3.1 дэх хэсгийн 3.1.1-т заасан тус хорооноос 2023 онд нээлттэй сонгон шалгаруулалтаар олгох өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн тоо (квот)-г тогтоох, батлуулах арга хэмжээг 2023 оны эхний хагас жилд багтаан хорооны хуралдаанд хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх нь зүйтэй гэж тогтов.

Зохицуулах хорооны 2022 оны ээлжит 12 дугаар хуралдаанд ӨНЗГ-аас хийсэн “Телевизийн хөтөлбөрт 2022 оны 1-10 сарын хугацаанд мониторинг хийсэн тайлан (KPI)-танилцуулга”-ыг сонсов. Тус хуралдаанаар ӨНЗГ-аас хийсэн мониторингийн дүгнэлт, үр дүнгээр авах арга хэмжээний санал, дүгнэлтийг зарчмын хувьд дэмжиж, тухайлбал мониторинг хамрагдсан өргөн нэвтрүүлгийн 18 телевизэд хөтөлбөрөөр хугацаатай үүрэг даалгавар албан тоотоор хүргүүлэх; арилжааны 16 телевизийн 6 телевиз-д шалгалтын дүн, зөвлөмж хүргүүлэх; 6 телевизийн тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх; 10 телевиз-д хугацаатай үүрэг даалгавар хүргүүлэх; 4 телевиз-д тусгай зөвшөөрлийн зөрчилтэй мэдэгдэл хүргүүлэх, 1 телевизийн тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх асуудлыг удирдлагад танилцуулах, шаардлагатай тохиолдолд хорооны хуралдаанд тухай бүр хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх нь зүйтэй гэж тогтов.

Харилцаа холбооны зохицуулах хороо нь “Харилцаа холбооны тухай” хуулийн 9.1.11 болон тус хуулийн 6.1.4-д заасан заасан бүрэн эрхийн хүрээнд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын даргын 2017 оны А/42 тоот тушаалаар батлагдсан “Тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд үзүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох журам”-ыг баталсан. Энэхүү журмыг үндэслэн ХХЗХ-ноос Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг 2017 оны 58 дугаар тогтоолоор шинэчлэн баталж, 2021 оны 25 тоот тогтоолоор Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд нэмэлт, өөрчлөлт оруулсан. Хорооны 2017 оны 58 дугаар тогтоол, 2 удаагийн тогтоолоор оруулсан холбогдох нэмэлт өөрчлөлтийг 2017 оны 12 сарын 27-ны өдөр ХЗДХЯ-ны захиргааны хэм хэмжээний актын улсын бүртгэлд 3824 дугаарт хянуулан бүртгүүлсэн ба өнөөг хүртэл хүчин төгөлдөр мөрдөж байна. УИХ-аар Зөвшөөрлийн тухай хуулийг 2022 оны 6-р сарын 17-ны өдөр соёрхон баталж, 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр болж мөрдөж эхэлнэ. Зөвшөөрлийн тухай хуулийн дагуу Харилцаа холбооны зохицуулах хороо нь нэр бүхий 13 тусгай зөвшөөрлийг олгохоор хуульчлагдсан болно. Ийнхүү харилцаа холбоо, өргөн нэвтрүүлэг, шуудангийн чиглэлээр нийт 29 төрлийн тусгай зөвшөөрөл олгодог байсныг Зөвшөөрлийн хуульд нийцүүлэн 13 төрлийн тусгай зөвшөөрөл болгон тоо хэмжээг бууруулсан. Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ эрхлэх үйл ажиллагаанаас хамааран ялгавартай тогтоогдон мөрдөж байсан бөгөөд хөлсний хэмжээг шууд нэгтгэх боломжгүй байгаа тул тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа явуулах төрлөөс хамааруулан ялгаатай тогтоох шаардлага гарсан байна. Иймээс зохицуулах хорооны 2022 оны ээлжит 12 дугаар хуралдаанд ЗЗҮТЗГ, ЗУХАГ, холбогдох бүтцийн нэгжээс хамтран Зөвшөөрлийн тухай, Захиргааны хэм хэмжээний баримт бичиг боловсруулах хууль, тогтоомжид нийцүүлэн боловсруулсан “Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ”-г шинэчлэн батлах тухай танилцуулга, үндэслэл судалгаа, тооцоолол, тогтоолын төсөл, хавсралт зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээний санал, саналын товчоо, нөлөөллийн шинжилгээ зэрэг баримт бичгийг тус тус хэлэлцэн шийдвэрлэв. Хэлэлцсэн асуудлаар, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.11, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын даргын 2017 оны А/42 тоот тушаалын хавсралтаар баталсан “Тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд үзүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох журам”-ыг тус тус үндэслэн ХХЗХ-ны 2022 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн ээлжит 12 дугаар хуралдааны 61 тоот “Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг шинэчлэн батлах тухай” тогтоолыг хавсралтын хамт баталсан болно. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Харилцаа холбооны зохицуулах хорооны 2017 оны 58 тоот тогтоол, 2021 оны 25 тоот тогтоолыг тус тус хүчингүй болгов. ХЗДХЯ-ны Захиргааны хэм, хэмжээ тогтоосон шийдвэрийн улсын бүртгэлд хянуулан бүртгүүлэхээр ХХЗХ-ны 2022 оны

01/1753 албан тоотор хүргүүлж, ХЗДХЯ-ны Захиргааны хэм, хэмжээ тогтоосон шийдвэрийн 6120 тоот улсын бүртгэлд 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр бүртгүүлэн баталгаажуулсан.

Тус хорооны хуралдаанаар ЗЗҮТЗГ-аас боловсруулсан “Давамгайл байдалтай үйлчилгээ эрхлэгч Юнивишн ХХК-ийн үндсэн үйлчилгээний үнэ тарифыг хянан батлах тухай” танилцуулга, тооцоолол судалгаа, саналын товчоо, тогтоолын төсөл, үнэ тариф бүхий хавсралтын төслийг авч хэлэлцээд, хуралдааны үеэр хорооны дарга, гишүүдээс гарсан зарчмын санал, зөвлөмжийг үндэслэн хорооны хуралдааны 2022 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн “Үнэ тарифын талаар хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” хуралдааны 13 дугаар Тэмдэглэлээр хугацаатай үүрэг даалгавар, удирдамж чиглэл болгох болон холбогдох тодруулга, судалгаа авах арга хэмжээг авч хэрэгжүүлэх, хорооны дараагийн ээлжит хуралдаанд дахин хэлэлцүүлэхийг Зах, зээл үнэ тарифын зохицуулалтын газарт даалгав.

ХХЗХ-ны 2022 оны ээлжит бус 02 дугаар хуралдаан (2022-12-16)-аар “Харилцаа холбооны зохицуулах хорооны 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөл болон төсвийн төсөл”-ийн анхны танилцуулга хэлэлцүүлгийг хийж, уг хорооны хуралдааны үеэр дарга, гишүүдээс өгсөн санал зөвлөмж болон үүрэг даалгавар, удирдамж чиглэлийг Ажлын хэсэг (Д.Сэрээдорж), Захиргааны удирдлага, хамтын ажиллагааны газраас тусган нэгтгэж боловсруулсан, шинэчилсэн хувилбарыг Зохицуулах хорооны 2022 оны ээлжит 12 дугаар хуралдаанд хэлэлцүүлэн шийдвэрлэв. Тус хуралдаанаар “Харилцаа холбооны зохицуулах хорооны 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөө (Нийтдээ төлөвлөгөөнд 84 бүтээгдэхүүний 300 ажил, үйл ажиллагаа төлөвлөгдсөнөөс Хорооны үйл ажиллагааны 2022-2025 оны дунд хугацааны стратегийн зорилтод чиглэсэн 33 бүтээгдэхүүний 143 үйл ажиллагаа, нийтлэг 51 бүтээгдэхүүний 157 үйл ажиллагааг багтаасан)-ний төсөл, 2023 оны орлого зардлын төлөвлөгөө, байгууллагын 2024-2025 оны төсвийн төсөөллийг батлах тухай” тухай танилцуулга, тогтоолын төсөл, хөрөнгө оруулалтын төсөл хөтөлбөр, төсөв тооцоо, орлого зардлын тооцоо судалгаа, төлөвлөгөөний төсөл, тогтоолын хавсралтууд болох “Харилцаа холбооны зохицуулах хороо (ХХЗХ)-ны 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний төсөл “ХХЗХ-ны 2023 оны орлогын төлөвлөгөө”-ний төсөл, “ХХЗХ-ны 2022 оны зардлын төлөвлөгөө”-ний төсөл, “ХХЗХ-ны 2023 оны хөрөнгө оруулалтын зардал”-ын төсөл, “ХХЗХ-ны 2023 оны хөтөлбөр, арга хэмжээний зардал”-ын төсөл, “ХХЗХ-ны 2023 оны үйл ажиллагааны зардал”-ын төсөл, “ХХЗХ-ны 2024-2025 оны төсвийн төсөөлөл”-ийн төслийг тус тус авч хэлэлцсэн. Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.16 дах заалт, Засгийн газрын 2016 оны 268 тоот тогтоолоор баталсан, Засгийн газрын 2020 оны 65 тоот тогтоолоор нэмэлт, өөрчлөлт оруулсан Харилцаа холбооны зохицуулах хорооны дүрмийн 4.3.2 дах заалтыг тус тус үндэслэн 2022 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн “Харилцаа холбооны зохицуулах хорооны 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, орлогын төлөвлөгөө, зардал 2024-2025 оны төсвийн төсөөлөл батлах тухай” 67 тоот тогтоолыг 7 хавсралтын хамт батлав. Энэхүү тогтоолын хавсралтаар (Тогтоол-67: Хавсралт-1: “Харилцаа холбооны зохицуулах хорооны 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”; Хавсралт-2: “ХХЗХ-ны 2023 оны орлогын төлөвлөгөө”; Хавсралт-3: “ХХЗХ-ны 2023 оны зардлын төлөвлөгөө”; Хавсралт-4: “ХХЗХ-ны 2023 оны хөрөнгө оруулалтын зардал”; Хавсралт-5: “ХХЗХ-ны 2023 оны хөтөлбөр, арга хэмжээний зардал”; Хавсралт-6: “ХХЗХ-ны 2023 оны үйл ажиллагааны зардал”; Хавсралт-7: “ХХЗХ-ны 2024-2025 оны төсвийн төсөөлөл”) баталсан Хорооны 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавьж,

батлагдсан зардал, төсвийг зориулалтын дагуу зарцуулан тухай бүр гүйцэтгэлийг тайлагнан ажиллахыг Хорооны дарга /Г.Чинзориг/-д даалгав.

Улсын Их Хурлаас 2022 оны 06 дугаар сард Зөвшөөрлийн тухай хуулийг соёрхон баталж, 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхлэхтэй холбогдуулан харилцаа холбооны салбарын зохицуулалтын дүрэм журам, баримт бичиг, нөхцөл шаардлагыг Зөвшөөрлийн тухай болон холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэх зорилгоор ХХЗХ-ны даргын 2022 оны А/222 тоот тушаалаар ажлын хэсэг байгуулан ажиллаж байна. Ажлын хэсгээс Зохицуулах хорооны 2022 оны ээлжит 12 дугаар хуралдаанд Зөвшөөрлийн тухай хуулийг хэрэгжүүлж эхлэхтэй холбогдуулан боловсруулсан зохицуулалтын багц арга хэмжээний тухай асуудлыг авч хэлэлцэн шийдвэрлэв. Үүнд:

- Засгийн газрын 2016 оны 268 дугаар тогтоолоор баталсан “Харилцаа холбооны зохицуулах хорооны дүрэм”-ийн 2.1.4 дэх заалтыг үндэслэн хорооны 2022 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 62 тоот “Харилцаа холбооны зохицуулах хорооны хуралдааны дэг”-д өөрчлөлт оруулах тухай тогтоолыг батлав. Тогтоолд, Зөвшөөрлийн тухай хуульд нийцүүлэн Харилцаа холбооны зохицуулах хорооны 2019 оны 28 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Харилцаа холбооны зохицуулах хорооны хуралдааны дэг”-д дараах өөрчлөлт оруулсугай. Үүнд: 1.1.Дэгийн 1.6 дах хэсгийн “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль” гэснийг “Зөвшөөрлийн тухай хууль” гэж өөрчлөх; 1.2.Дэгийн 1.11 дэх хэсгийн “болон “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам” гэснийг хассугай.гэжээ. Энэхүү тогтоолыг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөнө.
- Захиргааны ерөнхий хуулийн 48.2.1, Зөвшөөрлийн тухай хуулийн 1.5 дах зүйлийн 17 дах заалтыг үндэслэн хорооны 2022 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 63 тоот “Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай” тогтоолыг баталсан. Энэхүү тогтоолоор Харилцаа холбооны зохицуулах хорооны “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ыг шинэчлэн батлах тухай 2021 оны 34 дүгээр тогтоолыг хүчингүй болгов. ХЗДХЯ-ны Захиргааны хэм, хэмжээ тогтоосон шийдвэрийн улсын бүртгэлд хянуулан нэмэлтээр бүртгүүлэхээр ХХЗХ-ны Даргын 2023 оны 02/36 албан тоотоор хүргүүлэв. ХЗДХЯ-ны Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 5304 бүртгэлтэй 2021 оны 34 тоот тогтоолыг 2022 оны 63 тоот тогтоолын дагуу хүчингүй болгож, 2023 оны 01 дугаар сарын 23-ны өдөр ХЗДХЯ-ны бүртгэлээс хасав.
- Харилцаа холбооны тухай хуулийн 21.2, Монгол Улсын Их хурлын 2022 оны 35 дугаар тогтоолын 2 дах хэсгийг тус тус үндэслэн хорооны 2022 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 64 тоот “Дотоодын хэрэглээний холбооны сүлжээнд зохицуулалт хийх журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай тогтоолыг баталж, Зөвшөөрлийн тухай хуульд нийцүүлэн 2020 оны 65 тоот тогтоолоор батлагдсан журмын холбогдох хэсэгт нэмэлт оруулах, өөрчлөн найруулах, хасахаар тус тус шийдвэрлэв. ХЗДХЯ-ны Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэлтэй баримт бичигт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хянуулан бүртгүүлэхээр хүргүүлэв.
- Харилцаа холбооны тухай хуулийн 9.1.6 дэх заалт, Монгол Улсын Их хурлын 2022 оны 35 дугаар тогтоолын 2 дах хэсгийг тус тус үндэслэн хорооны 2022 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 65 тоот “Харилцаа холбооны зах зээлд шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх журам”-д өөрчлөлт оруулах тухай тогтоолыг баталж, Зөвшөөрлийн тухай хуульд нийцүүлэн хорооны 2021 оны 57 тогтоолоор баталсан журмын холбогдох хэсэгт өөрчлөлтүүд оруулахаар шийдвэрлэв. ХЗДХЯ-ны

Захиргааны хэм, хэмжээ тогтоосон шийдвэрийн улсын бүртгэлд хянуулан нэмэлтээр бүртгүүлэхээр ХХЗХ-ны Даргын 2022 оны 01/1754 албан тоотор хүргүүлэв. ХЗДХЯ-ны Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 5554 бүртгэлтэй 2021 оны 57 тоот тогтоолд оруулсан 2022 оны 65 тоот тогтоолыг хянаж үзээд, тогтоолоор оруулсан нэмэлтийг 2023 оны 02 дугаар сарын 02-ны өдөр ХЗДХЯ бүртгэсэн болно.

- Харилцаа холбооны тухай хуулийн 9.1.2 дах заалтыг хорооны 2022 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 66 тоот “Мэдээллийн сүлжээ ашиглах, үйлчилгээ эрхлэх зохицуулалтын журам” батлах тухай тогтоолыг батлав.

ХХЗХ-ны 2022 оны ээлжит 12 дугаар хуралдаанаар тусгай зөвшөөрлийн тухай (ТЗ шинээр олгох, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох, “Улаанбаатар хотын арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтын дүгнэлтээр тусгай зөвшөөрөл түдгэлзүүлэх тухай) холбогдох газар, хэлтсийн боловсруулсан танилцуулга, үнэлгээний дүгнэлт бүхий 5 тогтоолын төслийг хавсралтын хамт тус тус хэлэлцээд, тус хуралдаанаас 5 тогтоолыг хавсралтын хамт батлан шийдвэрлэсэн. Үүнд:

- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.1.2 дах заалт, 12 дугаар зүйл, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2021 оны 34 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 3 дугаар зүйлийн 3.5 дах хэсгийг тус тус үндэслэн 2022 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 68 тоот тогтоолын хавсралтаар 11 хуулийн этгээдэд 14 тусгай зөвшөөрлийг шинээр олгосон;
- Харилцаа холбооны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.15 дах заалт, 9 дүгээр зүйлийн 9.1.2 дах заалт, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2021 оны 34 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, 5.1.1 дэх заалт болон 5.3 дах хэсгийг тус тус үндэслэн 2022 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 69 тоот тогтоолын хавсралтаар 4 хуулийн этгээдийн 5 тусгай зөвшөөрөлд өөрчлөлт оруулсан;
- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5 дах заалт, 14 дүгээр зүйлийн 14.1.1 дэх заалт, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дах заалт, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2021 оны 34 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалтыг тус тус үндэслэн 2022 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 70 тоот тогтоолын хавсралтаар 3 хуулийн этгээдийн 3 тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон;
- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.4 дэх заалт, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дах заалт, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1 дэх заалт, 2021 оны 34 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалтыг тус тус үндэслэн 2022 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 71 тоот тогтоолын хавсралтаар 6 хуулийн этгээдийн 6 тусгай зөвшөөрлийг 60 хоногийн хугацаагаар түдгэлзүүлж тус тус шийдвэрлэв.

(Хуралдааны баталсан тогтоолын жагсаалт, холбогдох хавсралтыг <http://www.crc.gov.mn/main.php?cid=1&do=70&did=0> үзнэ үү).

Харилцаа холбооны зохицуулах хороо
2022-12-28